



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 1/346

Улаанбаатар хот

**Нийгмийн даатгалын байгууллагын албан
хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн
баталгааны хөтөлбөр батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг, 61 дүгээр зүйл, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгахыг Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар (Ц.Ганцэцэг)-т, хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Б.Даваахүү)-т тус тус үүрэг болгосугай.

3.Хөтөлбөртэй нийцүүлэн байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн батлах, жил бүрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнаж ажиллахыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нар, Мэдээллийн технологийн төвийн Захиралд тус тус үүрэг болгосугай.

4.Хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцон, тайлагнаж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар (Б.Ганхуяг)-т үүрэг болгосугай.


5.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Б.Даваахүү)-т даалгасугай.

ДАРГА

Б.БАТЖАРГАЛ



1505011318



משרד הבריאות

המנהל הכללי של משרד הבריאות, תל אביב, ישראל. **הודעה** .. (הודעה) ..

המנהל הכללי של משרד הבריאות, תל אביב, ישראל. **הודעה** .. (הודעה) ..

המנהל הכללי של משרד הבריאות, תל אביב, ישראל. **הודעה** .. (הודעה) ..

המנהל הכללי של משרד הבריאות, תל אביב, ישראל. **הודעה** .. (הודעה) ..

המנהל הכללי של משרד הבריאות, תל אביב, ישראל. **הודעה** .. (הודעה) ..

המנהל הכללי של משרד הבריאות, תל אביב, ישראל. **הודעה** .. (הודעה) ..

המנהל הכללי של משרד הבריאות, תל אביב, ישראל. **הודעה** .. (הודעה) ..

המנהל הכללי של משרד הבריאות, תל אביב, ישראל. **הודעה** .. (הודעה) ..



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН
АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ,
НИЙГМИЙН БАТАЛГААНЫ
ХӨТӨЛБӨР**

УЛААНБААТАР ХОТ
2025 ОН

АГУУЛГА

1. Нийтлэг үндэслэл
2. Нийгмийн даатгалын байгууллагын бүтэц, албан хаагчдын өнөөгийн байдал
 - 2.1.Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо, бүтэц, хүний нөөцийн мэдээлэл
 - 2.2.Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны талаарх өнөөгийн байдал
3. Хөтөлбөрийн зорилт
4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа
5. Хөтөлбөрийн үр дүн
6. Хөтөлбөрийн шалгуур
7. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын хяналт-шинжилгээ, үнэлгээ
8. Хавсралт
 - 8.1.Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө
 - 8.2.Хөтөлбөрийн ерөнхий зураглал
 - 8.3.Шаардагдах төсөв, хөрөнгийн тооцоо

НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмууд нь энэхүү хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болно.

1.2.Төрийн албан хаагчийн ажиллах урам зориг, хүсэл зорилгыг бий болгох, сэтгэл ханамжтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн, хөдөлмөрийн харилцаан дахь урамшуулал, идэвхжүүлэлтийн аргад тулгуурласан, олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад энэ хөтөлбөрийн зорилго оршино.

1.3.Энэхүү хөтөлбөрт Нийгмийн даатгалын байгууллагын нийт ажилтан, албан хаагчид хамрагдана.

Хоёр. Нийгмийн даатгалын байгууллагын бүтэц, албан хаагчдын өнөөгийн байдал

2.1.Нийгмийн даатгалын тогтолцоо, бүтэц, хүний нөөцийн мэдээлэл

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, сум, дүүргийн тасаг, нийгмийн даатгалын байцаагч, ажилтнаас бүрдэнэ.” гэж заасан байдаг.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны “Нийгмийн даатгалын төв болон орон нутгийн байгууллагын орон тооны хязгаарыг батлах тухай” А/45 дугаар тушаалаар нийгмийн даатгалын байгууллагын орон тооны хязгаарыг 1477 албан хаагчтай байхаар баталсан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/51, “Дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/52, “Бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/53 дугаар тушаалаар нийгмийн даатгалын байгууллагын бүтэц, албан тушаалын жагсаалт орон тоог батлан 2024, 2025 оны эхний 8 сард мөрдөн ажиллаж ирсэн.

Монгол Улсын Их Хурлын “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолоор төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилган, төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэхээр шийдвэрлэсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн дотоод бүтцийн нэгжийн тоог баталсан

бөгөөд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын орон тооны дээд хязгаар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” А/163 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын байгууллагын орон тооны хязгаарыг 1341 байхаар шинэчлэн баталсан.

Дээрх тушаалыг үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн “Нийгмийн даатгалын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн орон тоо, албан тушаалын жагсаалтыг батлах тухай” А/237 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан тушаалын жагсаалт, “Дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг батлах тухай” А/238 дугаар тушаалаар дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалтыг, “Аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг батлах тухай” А/239 дүгээр тушаалаар аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог, “Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг батлах тухай” А/236 дугаар тушаалаар Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн орон тоо, бүтэц, албан тушаалын жагсаалтыг, “Мэдээллийн технологийн төвийн бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг батлах тухай” А/235 дугаар тушаалаар Мэдээллийн технологийн төвийн бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг тус тус шинэчлэн баталсан. /Хүснэгт 1 /

Хүснэгт 1

№	Нэгжийн нэр	2024 онд батлагдсан орон тоо	2025 онд батлагдсан орон тоо	2024 оны жилийн эцсийн гүйцэтгэл
1.	Нийгмийн даатгалын ерөнхий газар	93	84	86
2.	Аймгийн Нийгмийн даатгалын газар /21/	909	824	834
3.	Дүүргийн Нийгмийн даатгалын газар /9/	436	399	401
4.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба	12	9	12
5.	Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл	8	7	6
6.	Мэдээллийн технологийн төв	19	18	16
7.	БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төв	8	7	8
	Нийт	1485	1341	1363

Нийгмийн даатгалын байгууллагад 2025 оны 1 дүгээр сард нийт 1363 албан хаагч ажиллаж байсан бөгөөд хүйс, мэргэжил, улсын байцаагчийн эрх болон мэргэшлийн зэрэгтэй албан хаагчдын мэдээллийг харууллаа. /Хүснэгт 2/

Хүснэгт 2

№	Мэдээлэл	Ангилал	Албан хаагчдын тоо /тоо/	Албан хаагчдын тоо /хувь/
1.	Хүйсийн харьцаа	Эр	290	21.2
		Эм	1076	78.8

2.	Албан тушаалын ангилал	Удирдах	113	8.2
		Гүйцэтгэх	1025	75.2
		Үйлчлэх	225	16.6
3.	Мэргэжлийн байдал	Санхүү, эдийн засагч	966	70.8
		Хуульч, эрх зүйч	92	6.7
		Бусад	305	22.5
4.	Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрхтэй байцаагч /835/	Нийгмийн даатгалын улсын байцаагч	835	61.9
5.	Мэргэшлийн зэрэгтэй байцаагч /429/	Тэргүүлэх зэрэг	77	17.9
		Зөвлөх	123	28.6
		Итгэмжит зөвлөх	229	53.5

2.2. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны талаарх өнөөгийн байдал

Нийгмийн даатгалын байгууллага нь өсөн дэвших эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэн үйл ажиллагаагаа цаг үргэлж сайжруулах, хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээг даатгуулагчдад хүргэхээр ажиллаж байна.

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд нь бүгд өөрийн конторын барилгатай бөгөөд ажлын байрны стандартад нийцсэн байдлаар засварлах, үйлчилгээний чанар стандартад нийцүүлэн тохижуулах ажлыг жил бүр хийсээр байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024, 2025 онд Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын газрын албан конторын зориулалттай барилга баригдаж байна.

Нийгмийн даатгалын байгууллагууд нь Төрийн албаны тухай хууль болон хууль тогтоомж, журмаар хамгаалагдсан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл, тэтгэвэр, тэтгэмж, мөнгөн урамшуулал буцалтгүй тусламж олгох асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. Албан хаагчдад Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу төрийн албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгохоос гадна нийгмийн даатгалын байгууллагад тогтвор суурьшилтай, мэргэшсэн албан хаагчтай байхад анхаарч Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгож, мэргэшлийн зэргийг жил бүр шинээр болон ахиулан олгож, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг сар бүр олгож байна.

Нийгмийн даатгалын байгууллага нь албан хаагчдынхаа нийгмийн баталгааг хангахад 2024 онд дараах мөнгөн дүнг олгожээ. /Хүснэгт 3/

Хүснэгт 3

№	Ажил, үйлчилгээ	Мөнгөн дүн / төгрөг /
1.	Цалин хөлс, нэмэгдэл, нөхөх төлбөр, урамшуулал	44,432,189.7
2.	Томилолтын зардал	511,445.4
3.	Дадлага хийх зардал	170,193.0
4.	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	545,524.5
5.	Тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж	995,351.2

6.	Орон нутагт тогтвор, суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох мөнгөн урамшуулал	2,917,646.3
7.	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,452.5
	Нийт	49,063,357.20

Гурав.Хөтөлбөрийн зорилт

3.1.Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

3.1.1.Цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж, мөнгөн урамшуулал, тусламж, дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх;

3.1.2.Ажиллах орчин, нөхцлийг сайжруулах, үр дүнтэй ажиллах нөхцөл бололцоог хангах;

3.1.3.Амьдрах орчин нөхцөлийг сайжруулах;

3.1.4.Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх;

3.1.5.Төрийн албан хаагчдын нийгмийн хэрэгцээ, шаардлагыг үндэслэн албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийг сайжруулах;

3.1.6.Мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах.

3.2.Хөтөлбөрийг дараах зарчмаар хэрэгжүүлнэ.

3.2.1.Төрийн алба, төрийн албан хаагчтай холбоотой хууль тогтоомжийг баримтлан ажиллах;

3.2.2.Мэргэшсэн, тогтвортой байх;

3.2.3.Төрийн албан хаагчийн ажлыг гүйцэтгэл, ур чадвар, үр дүнд суурилах;

3.2.4.Адил тэгш боломжоор хангагдах;

3.2.5.Ил тод, нээлттэй байх;

3.2.6.Бодитой үр дүнтэй байх;

3.2.7.Төрийн албан хаагчийн сахилга хариуцлага, ёс зүйг эрхэмлэх;

3.2.8.Байгууллагын нөөц боломжийг бүрэн дайчлах;

3.2.9.Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

3.2.10.Байгууллага, хамт олны идэвх, санаачилгыг дэмжих.

3.3.Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс санхүүжнэ.

3.3.1.Улсын төсвийн санхүүжилт;

3.3.2.Олон улсын байгууллагын дэмжлэг, төсөл, хөтөлбөр;

3.3.3.Бусад эх үүсвэр.

3.4.Энэхүү хөтөлбөрийг 2025-2028 он хүртэл хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1.Цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж, мөнгөн урамшуулал, тусламж, дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх зорилтын хүрээнд:

4.1.1.Засгийн газраас баталсан цалингийн сүлжээг баримтлан албан хаагчдын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож, олгох;

4.1.2.Төрийн албан хаагчдын ур чадвар, ажлын үр дүн, туршлагыг үндэслэн шатлан дэвшүүлэх;

4.1.3.Төрийн албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, улсын байцаагчид мэргэшлийн зэргийг шинээр болон ахиулан олгох, төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл болон хөдөлмөрийн гэрээнд заагдсан нэмэгдэл болон бусад нэмэгдэл олгох асуудлыг тухай бүр шийдвэрлэх;

4.1.4.Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны нөхөх төлбөрийг тухайн жилийн төсөв, эдийн засгийн байдалтай уялдуулан нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

4.1.5.Албан хаагчдад ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгохоос гадна бусад хэлбэрээр урамшуулах боломжийг судлан төсөвт багтаан шийдвэрлэн олгох;

4.1.6.Хууль тогтоомжид нийцүүлэн төрийн дээд одон медаль, салбарын болон бусад байгууллагын шагналаар шагнах, гадаад дотоодод сургалтад хамруулах, мэргэшил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэргээр урамшуулах;

4.1.7.Албан хаагчдын ээлжийн амралт, нөхөх төлбөр, тэтгэмж, буцалтгүй тусламж олгох асуудлыг Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн хууль, бусад тогтоол, журам, шийдвэр, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэх;

4.1.8.Нийгмийн даатгалын байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудын нийгмийн баталгааг "Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-д заасны дагуу хангах.

4.2.Ажиллах орчин, нөхцлийг сайжруулах, үр дүнтэй ажиллах нөхцөл бололцоог хангах зорилтын хүрээнд;

4.2.1.Байгууллагын барилга байгууламжийг засварлах, ажиллах өрөө тасалгааны засвар, ажлын байрны тохижилтыг орчин үеийн шаардлагад нийцсэн, стандартыг хангасан байдлаар тохижуулах, техник хэрэгсэл, тавилгаар хангах ажлыг шат дараатай төлөвлөн тухай бүр шийдвэрлэн ажиллах;

4.2.2.Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах;

4.2.3.Шинэ тоног төхөөрөмж, технологийг нэвтрүүлэх, цаасгүй технологи бий болгох, шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх арга замыг байнга эрэлхийлэх, нэвтрүүлэх;

4.2.4.Ажилтнуудын үдийн амралт болон илүү цагаар ажиллах үед нь богино хугацаанд алжаал тайлах амрах орчинг нөөц боломждоо тулгуурлан бий болгох;

- 4.2.5.Төрийн албан хаагчдын нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч, байгууллагын соёл, хамт олны уур амьсгалыг эерэг болгох;
- 4.2.6.Нөөц боломжид тулгуурлан ажилтан, албан хаагчдын хүүхдүүдэд зориулан өрөө эсвэл буланг гарган тохижуулах;
- 4.2.7.Эцэг эхийн зөвлөл, спортын зөвлөл, сургалтын баг, залуучуудын зөвлөл, ахлахуудын зөвлөл гэх мэт хамт олны сонирхол, хөгжилд тулгуурласан албан бус бүлэг, нэгдлийн санаачилгыг дэмжих, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;
- 4.2.8.Стресс менежмент болон харилцаа хандлага, байгууллагын соёлыг төлөвшүүлэх сургалт зохион байгуулах;
- 4.3.Амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд;
- 4.3.1.Төрийн албан хаагчдыг орон сууцны нөхцлөө сайжруулах зорилгоор банкнаас зээл авах болон ипотекийн зээл авахад хамтран ажилладаг банктай холбон дэмжлэг үзүүлэх.
- 4.3.2.Шинээр гэр бүл болсон залуу гэр бүлд санхүүгийн болон бусад хэлбэрийн тусламж, дэмжлэг үзүүлэх;
- 4.3.3.Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулагдаагүй буцалтгүй тусламж, нэг удаагийн тусламжийн зардлаас орон сууц, хашаа байшин худалдаж авахад дэмжлэг үзүүлэх.
- 4.4.Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх зорилтын хүрээнд;
- 4.4.1.Жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах талаар арга хэмжээ авах, энэ талаар зохих эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллах;
- 4.4.2.Байгууллага, хамт олноороо аливаа хорт зуршлаас татгалзан, амьдралын зөв хэвшил, дадал, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, санал санаачилгыг дэмжих, өрнүүлэх;
- 4.4.3.Хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэн спорт, нийтийн биеийн тамирын хөтөлбөр, соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулах, зохион байгуулсан арга хэмжээнд идэвхтэй оролцуулах, албан хаагчдыг үр бүтээлтэй амрах таатай нөхцөлийг хангах;
- 4.4.4.Эрүүл аж төрөх, чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэхийг дэмжиж жилд 1-ээс доошгүй удаа идэвхтэй амралт, аялал зохион байгуулах;
- 4.4.5.Дархлаажуулалтыг сайжруулах, витаминжуулах ажлыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах;
- 4.4.6.Жирэмсэн, амаржсан, хүүхэд асрах чөлөөтэй болон бусад шалтгаанаар чөлөөтэй албан хаагчдыг хамт олны аливаа арга хэмжээнд татан оролцуулах, хамруулахад санаачилгатай ажиллах;
- 4.4.7.Байгууллага хамт олноороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, ногоон хөгжлийн талаарх соёлын арга хэмжээг дэмжиж, эерэг уур амьсгалыг бүрдүүлэх, үр бүтээлтэй, зөв боловсон өнгөрөөх;

4.4.8.Байгууллага хамт олноороо ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж дэмжлэг үзүүлэх болон нийгэмд чиглэсэн хүмүүнлэгийн ажилд оролцох.

4.5. Төрийн албан хаагчдын нийгмийн хэрэгцээ, шаардлагыг үндэслэн албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийг сайжруулах зорилтын хүрээнд;

4.5.1.Удирдах, гүйцэтгэх албан тушаалтны хоорондын харилцаа, хандлагын хэв маягийг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийг дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлэх;

4.5.2.Байгууллагын дотоод бүтцийн нэгжүүдийн болон албан хаагчдын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах;

4.5.3.Байгууллагын дотоод нэгжийн уур амьсгалыг сайжруулах, зөв боловсон соёлыг төлөвшүүлэх ажлыг дэмжиж, сайн туршлагыг дэлгэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.

4.6 Мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамруулах зорилтын хүрээнд;

4.6.1.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/296 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Нийгмийн даатгалын байгууллагын сургалтын хөтөлбөр"-ийн дагуу нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг тасралтгүй сургах, мэргэшүүлэх.

Тав. Хөтөлбөрийн үр дүн

5.1.Байгууллагын соёл төлөвшсөн байна.

5.2.Албан хаагчид хууль тогтоомжоор олгогдсон сургалтын хөтөлбөр, нийгмийн баталгаагаар хангагдсан байна.

5.3.Ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, хөдөлмөрийн бүтээмжид ахиц дэвшил гарч, байгууллагын үйлчилгээний чанар дээшилсэн байна.

5.4.Албан хаагчдын ажиллах орчин, нийгмийн баталгаа, амьдралын чанар сайжирсан байна.

5.5.Албан хаагчид албан үүргээ гүйцэтгэх сэтгэл ханамж, урам зориг нэмэгдэж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдсэн байна.

5.6.Төрийн албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллаж, тасралтгүй мэргэшсэн тогтвортой ажиллах нөхцөл бүрдэнэ.

5.7.Эрүүл, аюулгүй ажлын байраар хангагдана.

Зургаа. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

6.1.Нийгмийн баталгааны боломжоор хангагдсан албан хаагчдын тоо, мөнгөн дүн;

6.2. Албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээ, үр дүнд суурилан олгосон урамшууллын хэмжээ;

6.3.Ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1.Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн шууд удирдлага нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, хэрэгжүүлэгч нь Захиргаа, удирдлагын газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд байна.

7.2.Хөтөлбөрт туссан асуудлаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон салбарын хэмжээний холбогдох эрхийн актад нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх зэргээр шаардлагатай арга хэмжээг авч болно. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлыг төлөвлөх, бусад санаа санаачилга гарган, холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

7.3.Захиргаа, удирдлагын газар нь нэгдсэн удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангаж, үр дүнг нэгтгэн тайлагнана.

7.4.Нийгмийн даатгалын байгууллага нь тухайн жилийн нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөг батлагдсан төсөвт багтаан гаргана.

7.5.Хяналт-шинжилгээ, үнэлгээг Дотоод аудит, мониторингийн газар хийж, үр дүнг Газрын даргын зөвлөлд танилцуулна.

7.6.Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг 4 жил тутам шинэчлэн гаргаж, Ерөнхий газрын даргаар батлуулна.

-oOo-



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 346 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
үйл ажиллагааны төлөвлөгөө

Арга хэмжээ		Хэрэгжүүлэх хугацаа				Хүрэх үр дүн	Хариуцагч
		2025 ОН	2026 ОН	2027 ОН	2028 ОН		
Зорилт 1. Цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж, мөнгөн урамшуулал, тусламж, дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх зорилтын хүрээнд							
Арга хэмжээ 1.1 Засгийн газрын баталсан цалингийн сүлжээг баримтлан албан хаагчдын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож олгох;		+	+	+	+	Төрийн албан хаагчийн цалин хөлс нэмэгдэж, нийгмийн баталгаагаар хангагдсан байна.	Нийгмийн даатгалын байгууллага
Арга хэмжээ 1.2 Төрийн албан хаагчдын ур чадвар, ажлын үр дүн, туршлагыг үндэслэн шатлан дэвшүүлэх;		+	+	+	+	Төрийн албан хаагчийн ур чадвар, мэргэшсэн байх, тогтвор суурьшилтай ажиллах боломж нэмэгдсэн байна.	
Арга хэмжээ 1.3 Төрийн албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, улсын байцаагчид мэргэшлийн зэргийг шинээр болон ахиулан олгох, төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл болон хөдөлмөрийн гэрээнд заагдсан нэмэгдэл болон бусад нэмэгдэл		+	+	+	+	Төрийн албан хаагчийн цалин хөлс нэмэгдэж, нийгмийн баталгаагаар хангагдсан байна.	

олгох асуудлыг тухай бүр шийдвэрлэх;							
Арга хэмжээ 1.4 Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны нөхөх төлбөрийг эдийн засгийн байдалтай уялдуулан нэмэгдүүлэх, олгох асуудлыг тухай бүр шийдвэрлэх;	+	+	+	+	+	Төрийн албан хаагчийн цалин хөлс нэмэгдэж, нийгмийн баталгаагаар хангагдсан байна.	
Арга хэмжээ 1.5 Албан хаагчдад ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгохоос гадна бусад хэлбэрээр урамшуулах боломжийг судлан төсөвт багтаан шийдвэрлэн олгох;	+	+	+	+	+	Төрийн албан хаагчийн тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэж, ажиллах урам нэмэгдсэн байна.	
Арга хэмжээ 1.6 Хууль тогтоомжид нийцүүлэн төрийн дээд одон медаль, салбарын болон бусад байгууллагын шагналаар шагнах, гадаад дотоодод сургалтад хамруулах, мэргэшил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэргээр урамшуулах;	+	+	+	+	+	Төрийн албан хаагчийн тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэж, ажиллах урам нэмэгдсэн байна.	
Арга хэмжээ 1.7 Албан хаагчдын ээлжийн амралт, нөхөх төлбөр, тэтгэмж, буцалтгүй тусламж олгох асуудлыг Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн хууль, бусад тогтоол, журам, шийдвэр,	+	+	+	+	+	Төрийн албан хаагчийн цалин хөлс нэмэгдэж, нийгмийн баталгаагаар хангагдсан байна.	

хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэх;						
Арга хэмжээ 1.8 Нийгмийн даатгалын байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудын нийгмийн баталгааг "Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-ын дагуу дэмжлэг үзүүлэх.	+	+	+	+		Ахмад настуудын амьдралын түвшин дээшилсэн байна.
Зорилт 2. Ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах, үр дүнтэй ажиллах нөхцөл бололцоог хангах зорилтын хүрээнд						
Арга хэмжээ 2.1 Байгууллагын барилга байгууламжийг засварлах, ажиллах өрөө тасалгааны засвар, ажлын байрны тохижилтыг орчин үеийн шаардлагад нийцсэн, стандартыг хангасан байдлаар тохижуулах, техник хэрэгсэл, тавилгаар хангах ажлыг шат дараатай төлөвлөн тухай бүр шийдвэрлэн ажиллах;	+	+	+	+		Барилга байгууламжийн гадаад болон дотоод өнгө үзэмж сайжирсан байна.
Арга хэмжээ 2.2 Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах;	+	+	+	+		Тав тухтай, эрүүл, аюулгүй ажиллах нөхцөл бүрдсэн байна.
						Нийгмийн даатгалын байгууллага

Арга хэмжээ 2.3 Шинэ тоног төхөөрөмж, технологийг нэвтрүүлэх, цаасгүй технологи бий болгох, шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх арга замыг байнга эрэлхийлэх, нэвтрүүлэх; Арга хэмжээ 2.4 Ажилтнуудын үдийн амралт болон илүү цагаар ажиллах үед нь богино хугацаанд алжаал тайлах амрах орчинг нөөц боломждоо тулгуурлан бий болгох; Арга хэмжээ 2.5 Төрийн албан хаагчдын нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч, байгууллагын соёл, хамт олны уур амьсгалыг зэрэг болгох; Арга хэмжээ 2.6 Нөөц боломжид тулгуурлан ажилтан, албан хаагчдын хүүхдүүдэд зориулан өрөө эсвэл буланг гарган тохижуулах; Арга хэмжээ 2.7 Эцэг эхийн зөвлөл, спортын зөвлөл, сургалтын баг, залуучуудын зөвлөл, ахмадуудын зөвлөл гэх мэт хамт олны сонирхол, хөгжилд тулгуурласан албан бус бүлэг, нэгдлийн	+	+	+	+	+	Албан хаагчдын ур чадвар нэмэгдсэн байна.
	+	+	+	+	+	Ажиллах орчин, албан хаагчдын сэтгэл ханамж дээшилсэн байна.
	+	+	+	+	+	Байгууллагын соёл, хамт олны уур амьсгал, ажил хийх урам зориг дээшилсэн байна.
	+	+	+	+	+	Албан хаагчдын гэр бүлийн амгалан байдал нэмэгдэж, тайван ажиллах нөхцөл бүрдсэн байна.
	+	+	+	+	+	Хамтын ажиллагаа, багаар ажиллах чадвар, ажлын бүтээмж нэмэгдсэн байна.

санаачилгыг дэмжих, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;										
Арга хэмжээ 2.8 Стресс менежмент болон харилцаа хандлага, байгууллагын соёлыг төлөвшүүлэх сургалт зохион байгуулах;									Албан хаагчдын сэтгэл санаа тайван болж, ажиллах урам нэмэгдсэн байна.	
Зорилт 3. Амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд										
Арга хэмжээ 3.1 Төрийн албан хаагчдыг орон сууцны нөхцөлөө сайжруулах зорилгоор банкнаас зээл авах болон ипотекийн зээл авахад хамтран ажилладаг банкттай холбон дэмжлэг үзүүлэх;	+		+		+		+		Амьдралын түвшин дээшилсэн байна.	Нийгмийн даатгалын байгууллага
Арга хэмжээ 3.2 Шинээр гэр бүл болсон залуу гэр бүлд санхүүгийн болон бусад хэлбэрийн тусламж, дэмжлэг үзүүлэх.	+		+		+		+		Сэтгэл санаа болон санхүүгийн байдал дээшилсэн байна.	
Арга хэмжээ 3.3 Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулагдаагүй буцалтгүй тусламж, нэг удаагийн тусламжийн зардлаас орон сууц, хашаа байшин худалдаж авахад дэмжлэг үзүүлэх.	+		+		+		+		Амьдралын түвшин дээшилсэн байна.	
Зорилт 4. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх зорилтын хүрээнд										
Арга хэмжээ 4.1 Жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд	+		+		+		+		Эрүүл байх, эрүүл амьдрах хэв маяг, дадал зуршилтай болсон байна.	Нийгмийн даатгалын байгууллага

хамруулах талаар арга хэмжээ авах, энэ талаар зохих эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллах;						
Арга хэмжээ 4.2 Байгууллага, хамт олноороо аливаа хорт зуршлаас татгалзан, амьдралын зөв хэвшил, дадал, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, санал санаачилгыг дэмжих, өрнүүлэх;	+		+	+	+	Хамт олонч сэтгэлгээ, багаар ажиллах дадал, зөв амьдралын хэв шинжтэй болсон байна.
Арга хэмжээ 4.3 Спорт, нийтийн биеийн тамирын хөтөлбөр, соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулах, зохион байгуулсан арга хэмжээнд идэвхтэй оролцох зэргээр хамт олны уур амьсгалыг зөв төлөвшүүлэх, албан хаагчдыг үр бүтээлтэй амрах таатай нөхцөлийг хангах;	+		+	+	+	Албан хаагчдыг үр бүтээлтэй, таатай амрах нөхцөл бүрдсэн байна.
Арга хэмжээ 4.4 Эрүүл аж төрөх, чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэхийг дэмжиж жилд 1-ээс доошгүй удаа идэвхтэй амралт, аялал зохион байгуулах;	+		+	+	+	Хамт олны уур амьсгал дээшилсэн байна.
Арга хэмжээ 4.5 Дархлаажуулалтыг сайжруулах, витаминжуулах ажлыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах;	+		+	+	+	Эрүүл амьдрал, зөв дадал, хандлагатай болсон байна.


Арга хэмжээ 4.6 Жирэмсэн, амаржсан, хүүхэд асрах чөлөөтэй болон бусад шалтгаанаар чөлөөтэй албан хаагчдыг хамт олны аливаа арга хэмжээнд татан оролцуулах, хамруулахад санаачилгатай ажиллах;	+	+	+	+	+	Албан хаагчдын уур амьсгал өөрчлөгдсөн байна.	
Арга хэмжээ 4.7 Байгууллага хамт олноороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, ногоон хөгжлийн талаарх соёлын арга хэмжээг дэмжиж, зэрэг уур амьсгалыг бүрдүүлэх, үр бүтээлтэй, зөв боловсон өнгөрөөх;	+	+	+	+	+	Эко амьдралын дадалтай болж, албан хаагчдын уур амьсгал өөрчлөгдсөн байна.байна.	
Арга хэмжээ 4.8 Байгууллага хамт олноороо ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж дэмжлэг үзүүлэх болон нийгэмд чиглэсэн хүмүүнлэгийн ажилд оролцох.	+	+	+	+	+	Бүсдэд хандах хандлага эерэгээр өөрчлөгдсөн байна.	
Зорилт 5. Төрийн албан хаагчийн нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч, байгууллагын соёл, хамт олны уур амьсгалыг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийг сайжруулах зорилтын хүрээнд							
Арга хэмжээ 5.1 Удирдах, гүйцэтгэх албан тушаалтны хоорондын харилцаа, хандлагын хэв маягийг өөрчлөх замаар албан хаагчдын	+	+	+	+	+	Албан хаагчдын харилцаа, хандлага сайжирсан байна.	Нийгмийн даатгалын байгууллага

ажлын байрны сэтгэл ханамжийг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;						
Арга хэмжээ 5.2 Байгууллагын дотоод нэгжүүдийн болон албан хаагчдын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах;	+	+	+	+	+	Албан хаагчдын ажлын ачаалал, ажил үүргийн давхардал арилсан байна.
Арга хэмжээ 5.3 Байгууллагын дотоод нэгжийн уур амьсгалыг сайжруулах, зөв боловсон соёлыг төлөвшүүлэх ажлыг дэмжиж, сайн туршлагыг дэлгэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.	+	+	+	+	+	Албан хаагчдын харилцаа, хандлага сайжирч, бусдад үлгэр дууриал үзүүлсэн байна.
Зорилт 6. Мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамруулах зорилтын хүрээнд						
Арга хэмжээ 6.1 Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/296 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын сургалтын хөтөлбөр”-ийн дагуу нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг тасралтгүй сургах, мэргэшүүлэх.	+	+	+	+	+	Албан хаагчдын мэдлэг, мэргэшил дээшилсэн байна. Нийгмийн даатгалын байгууллага

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 346 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааныг хөтөлбөр НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ЕРӨНХИЙ ЗУРАГЛАЛ





Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 05 өдрийн 346 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны
хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025-2028 оны төсвийн төсөөлөл

Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын төсөв

Иргэд даатгуулагчдад түргэн шуурхай үйлчлэх, албан хаагчдын ажиллах таатай орчныг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах, төсөв төсөөллийг жил бүр шинэчлэн гаргадаг. Хэмнэлтийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх бусад хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд жил бүрийн төсөв хасагдсаар байна. 2025 оны төсвийг батлагдсан төсвөөр 2026-2028 оны төсвийг инфляцитай уялдуулан гаргасан болно.

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа			
		2025 он /сая.төг/	2026 он /сая.төг/	2027 он /сая.төг/	2028 он /сая.төг/
1	Цалин хөлс, нэмэгдэл, нөхөх төлбөр, урамшуулал	51,713.4	49,373.1		
2	Томилолтын зардал	335.0	173.6		
3	Дадлага хийх зардал	65.3	38.8		
4	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300.4	3.7		
5	Тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж	1,403.2	432.2		
6	Орон нутагт тогтвор, суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох мөнгөн урамшуулал	442.5	231.3		
	Нийт дүн	54,259.8	50,252.7		
	Өмнөх оноос 10 хувиар буурах			45,227.4	49,750.2
	Өмнөх оноос 10 хувиар өсөх			55,278.0	60,805.8
	Тайлбар	2025-2026 оныг батлагдсан төсөв, төсөөллөөр, 2027-2028 оныг тухайн жилийн инфляцитай уялдуулан 10 хувиар буурах эсвэл 10 хувиар өсөх байдлаар тооцоолов.			